



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 05 өдөр

Дугаар 378

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны “Баруун босоо тэнхлэгийн авто зам барих” төслийн хүрээнд бий болсон нийт 851,177,000.00 (найман зуун тавин нэгэн сая нэг зуун далан долоон мянган) төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг хавсралтад заасан төрийн өмчит авто зам засвар арчлалтын компаниудад бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Тогтоолд заасан авто зам, засвар арчлалтын компанийн гүйцэтгэх захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх;

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002183

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 09 дугаар сарын 05-ны өдрийн  
378 дугаар тогтоолын хавсралт

Төрийн өмчит авто зам засвар арчлалтын компаниудын үндсэн хөрөнгөд бүртгэх  
хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, марк дугаар	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Анхны өртөг (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)	Хүлээн авах байгууллага
1	Автогрейдер FPU165C	2018	Ш	1	221,079,500.00	221,079,500.00	"Баянчандмань-АЗЗА" ТӨХК
2	Автогрейдер FPU165C	2018	Ш	1	221,079,500.00	221,079,500.00	"Хөвсгөл-АЗЗА" ТӨХК
3	Автогрейдер FPU165C	2018	Ш	1	221,079,500.00	221,079,500.00	"Талын зам" ТӨХК
4	Дугуйт Экскаватор FR-L619	2018	Ш	1	164,484,500.00	164,484,500.00	"Архангай-АЗЗА" ТӨХК
5	Дугуйт Экскаватор FR-L620	2018	Ш	1	164,484,500.00	164,484,500.00	"Ховд-АЗЗА" ТӨХК
6	Ачигч FL935E-II	2018	Ш	1	116,403,250.00	116,403,250.00	"Ховд-АЗЗА" ТӨХК
7	Автогрейдер FPU165C	2018	Ш	1	221,079,500.00	221,079,500.00	"Увс-АЗЗА" ТӨХК
8	Ачигч FL935E-II	2018	Ш	1	116,403,250.00	116,403,250.00	"Увс-АЗЗА" ТӨХК
9	Ачигч FL935E-II	2018	Ш	1	116,403,250.00	116,403,250.00	"Талын зам" ТӨХК
10	Ачигч FL935E-II	2018	Ш	1	116,403,250.00	116,403,250.00	"Завхан-АЗЗА" ТӨХК
				10	851,177,000.00	851,177,000.00	
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>			10 (арав)	851,177,000.00 (найман зуун тавин нэгэн сая нэг зуун далан долоон мянган)	851,177,000.00 (найман зуун тавин нэгэн сая нэг зуун далан долоон мянган)	